



VII-IX/2021

Тархаасан: 2021 оны 10 дугаар сарын 14



Ажил эрхэлж буй гадаадын иргэд өмнөх улирлаас 9.4 хувиар өсжээ


Манай улсад 2021 оны 3 дугаар улирлын эцэст гадаадын 74 улсын 5.8 мянган иргэн хөдөлмөрийн гэрээгээр цалин хөлс, орлого олох зорилготойгоор хөдөлмөр эрхэлж, мөн цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байна. Ажил эрхэлж буй гадаад иргэдийн тоо өмнөх улирлаас 495 (9.4%) хүнээр өссөн байна.

Ажил эрхэлж буй гадаадын иргэдийн 5.2 (89.4%) мянга нь эрэгтэй, 0.6 (10.6%) мянга нь эмэгтэй байна. Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй нийт гадаадын иргэдийн 65.3 хувь нь БНХАУ-ын, 4.2 хувь нь Вьетнам Улсын, 3.7 хувь нь ОХУ-ын, 3.2 хувь нь БНСУ-ын, 3.0 хувь нь БНЭУ-ын, 2.5 хувь нь АНУ-ын, 2.0 хувь нь Филиппин Улсын, 1.1 хувь нь Их Британи Улсын, 1.1 хувь нь Австрали Улсын, 13.9 хувь нь бусад улсын харьяат байна.

Ажил эрхэлж буй гадаадын иргэдийн хамгийн их буюу 16.7 хувь нь 50-54 насныхан, 15.9 хувь нь 45-49 насныхан, 14.3 хувь нь 35-39 насныхан байгаа бол хамгийн бага буюу 2.5 хувь нь 24 хүртэлх насныхан байна.

Ажил эрхэлж байгаа гадаадын иргэдийн 2.7 (47.0%) мянга нь Улаанбаатарт, 2.1 (35.9%) мянга нь Төвийн бүсэд, 0.4 (7.0%) мянга нь Зүүн бүсэд, 0.3 (5.3%) мянга нь Хангайн бүсэд, 0.3 (4.8%) мянга нь Баруун бүсэд ажиллаж байна.

ЗУРАГ 1. АЖИЛ ЭРХЭЛЖ БАЙГАА ГАДААДЫН ИРГЭД, насны бүлэг, хүйс, дүнд эзлэх хувиар, 2021 оны 3 дугаар улирлын байдлаар



Ажил эрхэлж байгаа гадаадын иргэдийн 2.3 (39.4%) мянга нь дипломын болон бакалаврын дээд, 1.9 (34.3%) мянга нь техникийн болон мэргэжлийн, 1.1 (18.9%) мянга нь бүрэн дунд, 0.3 (5.8%) мянга нь тусгай мэргэжлийн дунд, 0.1 (1.6%) мянга нь суурь боловсролтой байна.


Ажил эрхэлдэг гадаадын иргэдийн хамгийн их буюу 2.7 (47.5%) мянга нь мэргэжилтэн, хамгийн бага буюу 3 (0.1%) иргэн хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтнаар ажиллаж байна.

ЗУРАГ 2. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, ажил мэргэжлийн ангилал, дүнд эзлэх хувиар, 2021 оны 3 дугаар улирлын байдлаар



Манай улсад 2021 оны 3 дугаар улиралд ажил эрхэлж буй гадаадын иргэдийн 1.7 (29.6%) мянга нь барилгын, 1.6 (28.0%) мянга нь уул уурхай, олборлолтын, 597 (10.4%) нь боловсролын, 526 (9.1%) нь боловсруулах үйлдвэрлэлийн, 443 (7.7%) нь тээвэр ба агуулахын үйл ажиллагааны, 351 (6.1%) нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 91 (1.6%) нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны, 434 (7.5%) нь бусад салбарт ажиллаж байна. Өмнөх улиралтай харьцуулахад, тухайлбал барилгын салбарт ажил эрхэлж буй гадаадын иргэд 721 (73.5%) хүнээр, тээвэр ба агуулахын салбарт 237 (2.2 дахин) хүнээр өссөн байна.

ЗУРАГ 3. ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭГЭЭР АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ГАДААДЫН ИРГЭД, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, дүнд эзлэх хувиар, улирлаар



Байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзэхэд 4.6 (79.9%) мянга нь хязгаарлагдмал хариуцлагатай компанид, 0.4 (8.4%) мянга нь төсөвт байгууллагад, 0.3 (5.3%) мянга нь төрийн өмчит аж ахуйн оролцоотой үйлдвэрийн газарт, 0.4 (6.4%) мянга нь бусад байгууллагад ажиллаж байна.

Ойлголт, тодорхойлолт

Хөдөлмөрийн гэрээгээр ажил эрхэлж буй гадаадын иргэн нь цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй ажиллагчид болон төрийн бус байгууллага, олон улсын хүмүүнлэгийн байгууллага, шашны байгууллагад цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байгаа хүмүүс юм.

Гадаад иргэдэд ажил эрхлэх үйлчилгээг “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах” тухай хууль, Засгийн газраас тухай бүр батлан гаргадаг гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахтай холбоотой тогтоол шийдвэрийн хүрээнд үзүүлдэг. “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 15.1.4, 8, 9-р заалтын дагуу “HG”, “O” болон “SH” ангиллын визээр гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээ болон уригч талын хөдөлмөрийн гэрээгээр ирсэн гадаадын иргэдэд ажил эрхлэх зөвшөөрөл олгож байна.

“HG” ангиллын визээр цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй ажиллагчид гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээгээр ирж ажиллана.

“SH” ангиллын визээр шашны байгууллагын урилгаар (i) цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй ажиллагчид, (ii) цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байгаа гадаад иргэд хөдөлмөрийн гэрээгээр ирж ажиллана.

“O” ангиллын визээр төрийн бус байгууллага, олон улсын хүмүүнлэгийн байгууллагын урилгаар цалин, хөлс, орлого олох зорилгогүйгээр сайн дурын ажил хийж байгаа гадаад иргэд хөдөлмөрийн гэрээгээр ирж ажиллана.



Эх үүсвэр

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Мэдээлэл авах холбоос

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь

2022 оны 1 дүгээр сарын 14

Нийгмийн статистикийн газар Өрхөд
суурилсан судалгааны хэлтэс
статистикч Б.Лхагвасайхан
Утас : (976-51)-265543

Нийгмийн статистикийн газрын
дарга А.Амарбал
Утас : (976-51)-264805



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212